



Захиргааны хэм хэмжээний  
актын улсын нэгдсэн санд  
2020 оны 09 сарын 09-ны  
өдрийн 4864 дугаарт бүртгэв.

**ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР, ХАРИЛЦАА  
ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА НАРЫН  
ХАМТАРСАН ТУШААЛ**

2020 оны 08 сарын 27 өдөр

Дугаар А/200/А/169

Улаанбаатар хот

┌ Журам батлах тухай ┐


Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.13, Харилцаа, холбооны зохицуулах хорооны дүрмийн 3.1.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Цар тахлын талаар олон нийтийг төөрөгдүүлэх, илт худал мэдээлэл цахим орчинд тархахаас сэргийлэх зорилгоор цахим орчинд зохицуулалт хийх журам”-ыг хавсралтаар баталсугай.


2. Энэхүү журмыг хэрэгжүүлж ажиллахыг Цагдаагийн ерөнхий газрын Дэд дарга /цагдаагийн хурандаа Ж.Амгалан/, Харилцаа холбооны зохицуулах хорооны Захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газрын дарга /З.Эрдэнэчулуун/-д тус тус даалгасугай.

3. Тушаалыг улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ  
ГАЗРЫН ДАРГА, ЦАГДААГИЙН  
ХУРАНДАА Ж.БОЛД



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ  
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ДАРГА Г.ЧИНЗОРИГ



Цагдаагийн ерөнхий газрын дарга,  
Харилцаа холбооны зохицуулах хорооны  
дарга нарын 2020 оны 08 дугаар сарын 27  
өдрийн А/200.14/169 дугаар хамтарсан  
тушаалын хавсралт

УХГН025

## ЦАР ТАХЛЫН ТАЛААР ОЛОН НИЙТИЙГ ТӨӨРӨГДҮҮЛЭХ, ИЛТ ХУДАЛ МЭДЭЭЛЭЛ ЦАХИМ ОРЧИНД ТАРХАХААС СЭРГИЙЛЭХ ЗОРИЛГООР ЦАХИМ ОРЧИНД ЗОХИЦУУЛАЛТ ХИЙХ ЖУРАМ

### Нэг. Ерөнхий зүйл

1.1. Энэхүү журмаар “Коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль”-ийн 9.13 дахь хэсэгт заасан Цар тахлын талаар олон нийтийг төөрөгдүүлэх, илт худал мэдээлэл цахим орчинд тархахаас сэргийлэх зорилгоор цахим орчинд зохицуулалт хийхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Цар тахлын талаар олон нийтийг төөрөгдүүлэх, илт худал мэдээлэл цахим орчинд тархах, сэргийлэх зорилгоор цахим орчинд зохицуулалт хийхдээ Монгол Улсын Үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан хууль тогтоомж болон энэ журмыг дагаж мөрдөнө.

1.3. Үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгч, интернэтийн үйлчилгээ эрхлэгч болон цахим орчны үйлчилгээ эрхлэгч (цахим хуудас, цахим орчин дахь олон нийтийн сүлжээ, аппликэйшн, гэх мэт) нь цар тахлын хугацаанд холбогдох хууль тогтоомж болон энэ журмыг дагаж мөрдөнө.

1.4. Цар тахлын эрсдэлийг далимдуулан бараа бүтээгдэхүүний зохиомол хомсдол, үнийн хөөргөдөл, хэрэглэгчийг хуурч мэхлэх, төөрөгдүүлэх, эмх замбараагүй байдал үүсгэхэд чиглэсэн мэдээлэл зэрэг нь энэ журмын 1.1 дэх хэсэгт хамаарна.

1.5. Цар тахлын талаар олон нийтийг төөрөгдүүлэх, илт худал мэдээлэл цахим орчинд тархахаас сэргийлэх зорилгоор цахим орчинд зохицуулалт хийхэд хууль дээдлэх, үнэн бодит баримтад суурилсан байх, түргэн шуурхай, нийтийн эрх ашигт нийцсэн байх зарчмыг баримтална.

### Хоёр. Цахим орчинд цар тахлын үед худал мэдээлэл тарааж байгаад хяналт тавих

2.1. Цахим орчинд цар тахлын үед худал мэдээлэл тарааж байгаад цагдаагийн байгууллага, мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар хяналт тавина.

2.2. Энэ журмын 2.1-д заасан эрх бүхий байгууллага нь цахим орчинд цар тахлын үед худал мэдээлэл тарааж байгаатай холбоотой асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хянан үзээд зохицуулалт хийх санал, дүгнэлтийг Харилцаа холбооны зохицуулах хороонд хүргүүлнэ.

2.3. Энэ журмын 2.2-т заасан санал, дүгнэлтэд тухайн хууль зөрчсөн мэдээ, мэдээллийн цахим хаяг, цахим холбоос, хэвлэмэл баримт зэрэг шаардлагатай баримтыг хавсаргана.

2.4. Харилцаа холбооны зохицуулах хороо нь энэ журмын 2.2-д заасан санал, дүгнэлтийн дагуу дараах мэдэгдлийг цахим орчны үйлчилгээ эрхлэгчдэд хүргүүлнэ.

2.4.1.мэдэгдэлд дурдсан мэдээ, мэдээллийг устгах, эсхүл хандалтыг хязгаарлах;

2.4.2.мэдэгдэлд дурдсан цахим хаяг, цахим хуудсыг цар тахлын хугацаа дуустал хандалтыг хязгаарлах.

2.5.Цахим орчны үйлчилгээ эрхлэгч нь энэ журмын 2.4-т заасан мэдэгдэлд дурдсан арга хэмжээг заасан хугацаанд даруй хэрэгжүүлж, хэрэгжилтийн талаарх мэдээллийг Харилцаа холбооны зохицуулах хороонд цахим шуудан, утсаар мэдэгдэж, албан бичгээр хүргүүлнэ.

2.6.Цахим орчны үйлчилгээ эрхлэгчийг олж тогтоох боломжгүй эсхүл энэ журмын 2.5-д заасан арга хэмжээг хэрэгжүүлээгүй бол Харилцаа холбооны зохицуулах хороо дараах мэдэгдлийг үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгч болон интернэтийн үйлчилгээ эрхлэгчид хүргүүлнэ:

2.6.1.тухайн цахим орчны үйлчилгээ эрхлэгчийн Монгол Улсаас хандах хандалтыг цар тахал намдах хүртэл зөрчлийг арилгах хугацаанд хязгаарлах;

2.6.2.шаардлагатай технологийн арга хэмжээ авах.

2.7.Үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгч болон интернэтийн үйлчилгээ эрхлэгч нь энэ журмын 2.6-д заасан мэдэгдэлд дурдсан арга хэмжээг заасан хугацаанд даруй хэрэгжүүлэх үүргийг хүлээх бөгөөд хэрэгжилтийн талаарх мэдээллийг Харилцаа холбооны зохицуулах хороонд цахим шуудан, утсаар мэдэгдэж, албан бичгээр хүргүүлнэ.

2.8.Харилцаа холбооны зохицуулах хороо нь энэ журмын 2.5, 2.7-д заасан мэдэгдлийг тухайн үйлчилгээ эрхлэгчийн цахим орчин дахь хаяг эсхүл Харилцаа холбооны зохицуулах хороонд бүртгэлтэй цахим шуудангаар хүргүүлснээр мэдэгдсэнд тооцно.

### **Гурав. Эрх бүхий байгууллагуудын хамтын ажиллагаа**

3.1.Цахим орчинд цар тахлын үед нийтийг төөрөгдүүлэх, илт худал мэдээ, мэдээлэл тарааж байгаа цахим орчинд хязгаарлалт хийх хүрээнд холбогдох эрх бүхий байгууллагууд хуульд заасан чиг үүргийн хүрээнд хамтран ажиллана.

3.2.Энэ журмын 3.1-д заасан эрх бүхий байгууллага гэдэгт тагнуулын байгууллага, цагдаагийн байгууллага, мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Харилцаа холбооны зохицуулах хороо, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар хамаарна.

3.3.Эрх бүхий байгууллагууд нь хамтран ажиллах албан тушаалтны овог, нэр, албан тушаал, хөдөлгөөнт болон суурин утасны дугаар, факсын дугаар, цахим хаягийн жагсаалтыг гаргасан байна.

3.4.Энэ журмын 3.2-д заасан эрх бүхий байгууллага нь цахим орчинд цар тахлын үед нийтийг төөрөгдүүлэх худал мэдээ, мэдээлэл тараасан гэмт хэргийн болон зөрчлийн шинжтэй үйлдлийг харьяаллын дагуу шалгуулахаар холбогдох байгууллагад шилжүүлнэ.

### **Дөрөв. Бусад холбогдох байгууллагын эрх үүрэг**

4.1.Үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгч болон интернэтийн үйлчилгээ эрхлэгч нь дараах үүрэгтэй:

4.1.1. цахим орчинд цар тахлын үед нийтийг төөрөгдүүлэх, илт худал мэдээ, мэдээлэл тарааж байгаа цахим орчинд хязгаарлалт хийх хүрээнд хамтран ажиллах төлөөлөгч болон түүнийг эзгүйд орон ажиллах албан тушаалтныг томилж, овог, нэр, албан тушаал, хөдөлгөөнт болон суурин утасны дугаар, цахим шуудангийн хаягийг Харилцаа холбооны зохицуулах хороонд бүртгүүлэх;

4.1.2. цахим орчинд цар тахлын үед нийтийг төөрөгдүүлэх, илт худал мэдээ, мэдээлэл тарааж байгаа цахим орчинд хязгаарлалт хийх энэ журмыг хэрэгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагааг тасралтгүй явуулах нөхцөл бололцоогоор хангах;

4.1.3.интернэтийн үйлчилгээ эрхлэгч нь зөрчилтэй домэйн нэрийн жагсаалт /black-list.mn/-ыг өөрийн сүлжээнд даруй хязгаарлах;

4.1.4.интернэтийн үйлчилгээ эрхлэгч нь домэйн нэрийн сервер (Domain Name Server)-тээ болон сүлжээний хамгаалалтын төхөөрөмж (Firewall)-дөө "www.black-list.mn" домэйн нэрт харгалзах АйПи (IP) хаягаас ирэх домэйн нэрийн асуулга, хүсэлтийг зөвшөөрөх, хариулах боломжийг бүрдүүлсэн байх;

4.1.5.интернэтийн үйлчилгээ эрхлэгч нь интернэтийн үйлчилгээнд ашиглаж буй домэйн нэрийн серверүүд (Domain Name Server)-ийн АйПи (IP) хаягууд болон хариуцан ажилладаг ажилтан болон түүнийг эзгүйд орлон ажиллах төлөөлөгч томилж, овог, нэр, албан тушаал, цахим шуудангийн хаяг, утасны дугаар зэрэг мэдээллийг Харилцаа холбооны зохицуулах хороонд бүртгүүлэх;

4.1.6.худал мэдээллийн хор уршгийг таниулах, соён гэгээрүүлэх ажил, сэрэмжлүүлэг, анхааруулгыг цахим хуудас болон олон нийтийн сүлжээгээр өгч байх.

4.2.Цахим орчны үйлчилгээ эрхлэгч нь дараах үүрэгтэй:

4.2.1.цахим орчинд цар тахлын үед нийтийг төөрөгдүүлэх, илт худал мэдээ, мэдээлэл тарааж байгаа цахим орчинд хязгаарлалт хийх хүрээнд хамтран ажиллах төлөөлөгч болон түүнийг эзгүйд орлон ажиллах төлөөлөгч томилж, овог, нэр, албан тушаал, хөдөлгөөнт болон суурин утасны дугаар, цахим шуудангийн хаягийг Харилцаа холбооны зохицуулах хороонд бүртгүүлэх;

4.2.2.цахим орчинд цар тахлын үед нийтийг төөрөгдүүлэх, илт худал мэдээ, мэдээлэл тарааж байгаа цахим орчинд хязгаарлалт хийх энэ журмыг хэрэгжүүлэхтэй холбоотой техник технологийн боломжийг заавал хангасан байх;

4.2.3.эрх бүхий байгууллагаас ирүүлсэн заавар, зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг даруй авч хариуг мэдэгдэх;

4.2.4.худал мэдээллийн хор уршгийг таниулах, соён гэгээрүүлэх ажил, сэрэмжлүүлэг, анхааруулгыг цахим хуудас болон олон нийтийн сүлжээгээр өгч байх.

## **Тав. Хариуцлага**

5.1.Энэ журмыг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---